

## ШАРГА СУМД 2017 ОНЫ 2 ДУГААР САРД БОЛСОН

### ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДЛЫН МЭДЭЭ

2017.02.23

Баянгол

#### **ХУУЛЬ СУРТАЛЧЛАХ АРГА ХЭМЖЭЭ ЗОХИОН БАЙГУУЛЛАА**

2017 оны эрх зүйн сургалт сурталчилгааны төлөвлөгөөний биелэлтийг хангаж төлөвлөгөөнд тусгагдсан хууль тогтоомжийг сурталчлах, иргэдийн идэвх оролцоо, хууль эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх зорилгоор хууль сурталчлах арга хэмжээг 2017.02.10-ны өдөр зохион байгууллаа. Сургалтанд Иргэд, Төрийн албан хаагч, 12 жилийн сургуулийн ахлах, дунд ангийн сурагчид, Гэмт хэрэг зөрчилд холбогдож болзошгүй иргэдийг хамруулсан. 105 иргэн, 65 хүүхэд оролцсон байна.

Сургалтыг Сумын ИТХ-ын дарга Б.Мандах нээж Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулиар Аймгийн Цагдаагийн газрын гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг хариуцсан ахлах байцаагч Д.Болорма, Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулиар Аймгийн Замын цагдаагийн тасгийн ахлах дэслэгч Б.Мөнхнасан нар иргэдэд мэдээлэл хийсэн.



Говь-Алтай аймгийн замын цагдаагийн гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тасгийн ахлах байцаагч, хошууч Д. Болормаа, замын цагдаагийн зохицуулагч Б.Мөнхнасан нар 6-12-р ангийн суралцагчдад болон багш, ажилчдад “Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль” “Хүүхдийн эрхийн тухай хууль”, “Хүүхэд хамгааллын тухай хууль” замын хөдөлгөөний дүрмийн талаар сургалт зохион байгууллаа.

## СУМЫН ЗАСАГ ДАРГЫН МӨРИЙН ХӨТӨЛБӨР БОЛОВСРУУЛАХ АЖИЛ ХИЙГДЭЖ БАЙНА

Сумын засаг дарга М.Тунгалагтамир 2 сарын 21-д эмнэлгийн ажилчидтай, 2 сарын 22-нд сургуулийн хамт олонтой уулзалт хийж, цаг үеийн мэдээлэл, цаашид хийж хэрэгжүүлэх



ажлыг танилцуулж, 2017-2020 онд хэрэгжүүлэх мөрийн хөтөлбөрт тусгуулах ажлын саналыг хүлээн авч эмч багш, ажилчдын санал хүсэлтийг хүлээн авлаа. Мөн мөрийн хөтөлбөр боловсруулах ажлын хэсгийг 2017 оны А\07 тоот захирамжаар байгуулан ажиллаж байна.

### БОЛОВСРОЛЫН ТАЛААР:

2 сарын 1-7 –ны хооронд багш нарын дунд хамтын хичээл зохион байгуулж, 18 багш хос хосоороо 9 хичээл хамтран заалаа. Давхардсан тоогоор 54 багш хичээлд сууж хэлэлцүүлэгт оролцлоо.



2017 оны ЭЕШ журмыг багш, суралцагч, эцэг эхчүүдэд танилцуулж, 2 сарын 20-22-ны хооронд 12-р ангийн 15 сурагчийг ЭЕШ-ын онлайн бүртгэлд бүртгэлээ. 12-р ангийн сурагчдаас нийгмийн ухаан, англи хэл, монгол хэл, математик зэрэг хичээлүүдээр ЭЕШ-ыг урьдчилсан байдлаар авч, дүнг танилцуулан анализ хийн ажиллаж байна.

Сурагчийн өөрөө удирдах байгууллага Янзага клубын сурагчид нийгмийн ажилтантай хамтран “Цэвэр орчин бидний ирээдүй” эко үйл ажиллагааг эхлүүлж, дотуур байрны



сурагчдыг уриалан орчныхоо хогийг цэвэрлэн судлан шинэжилж, юуны хог хаана илүү төвлөрч байна гэдэгт дүн шинжилгээ хийгээд байна.



2017 оны 2 сарын 1,2-ны өдрүүдэд Захирал Н.Идэрмөнх, нийгмийн ажилтан Н.Мөнхзул болон сумын хамтарсан багийн бүрэлдэхүүн “Хүн ам, нийгмийн хамгааллын чиглэлээр баримталж буй төрийн бодлого-эрхзүйн шинэсэдэвт нэгдсэн сургалтад хамрагдсан.



2 сарын 14-ний өдөр бүжгийн сонгоны сурагчид “Үндэсний бүжгээр амьсгалхуй” тайлан тоглолт зохион байгууллаа. Нийт бүжгийн сонгоны 50 сурагч оролцож, эцэг эх, иргэд хөдөлмөрчид, суралцагчдыг хамруулан сэтгэл ханамж сайн үнэлгээтэйгээр зохион байгууллаа.

2 сарын 15,16-ны өдрүүдэд аймгийн аварга шалгаруулах спортын наадам зохион байгуулагдаж, бүсээс шалгарсан волейболын /эмэгтэй/ 7 сурагч, теннис /эрэгтэй / -2 сурагч, теннис /эмэгтэй/-1 сурагч, чөлөөт бөхийн төрөлд 5 сурагч, жүдо бөхийн төрөлд 6 сурагч оролцлоо. Чөлөөт бөхийн төрөлд Б.Давдаваа -3-р байр, Л.Сарантуул 1-р байр, жүдо бөхийн төрөлд Ц.Бөхсумьяабазар -3-р байр, Б.Хулганаа 2-р байр тус тус эзэллээ.



2017 оны 2 сарын 16-20-ны хооронд нийгмийн ажилтан Н.Мөнхзул Увс аймагт нийгмийн ажлын туршлага солилцох сургалтад хамрагдлаа.



### АЙМАГ, СУМЫН АВАРГА МАЛЧИД ТОДОРЛОО

Аймгийн засаг даргын зөвлөлийн хурлаар аймгийн аварга малчин, аварга саальчин, аварга тариаланчийн болзол хангасан малчин тариаланчийн шалгаруулалт хийж 18 сумын 63 малчинг “Аймгийн аварга малчинаар, Тайшир, Цогт сумын 2 саальчинг “Аймгийн аварга саальчин”-аар, Бигэр сумын нэг тариаланчийг “Аймгийн аварга тариаланч”-аар тус тус шалгарууллаа. Манай сумаас Баянгол багийн малчин Г.Ган-очир (үхэр өсгөх болзлоор), П.Түвшин (тэмээ өсгөх болзлоор), Б.Нямдорж, Хамтын хүч багийн малчин Э.Пүрэвсүрэн, Улаантуг багийн малчин Б.Батмөнх нар аймгийн аварга малчнаар тодорлоо.

Сумын аварга малчнаар: Баянгол багийн малчин Н.Очирбат, Б.Лхагвадорж, Б.Тэгшбүрэн, Д.Баттөр, Хамтын хүч багийн малчин Я.Чимгээ, П.Батдэлгэр, Г.Баянмөнх, Х.Лхагвадорж, Улаантуг багийн малчин Э.Ганзориг, З.Баянмөнх, Л.Баасан, Ц.Баясгалан, Н.Батжаргал, А.Буяндэлгэр нар тодорсон байна.

### БӨХӨН МЯЛЗАН ӨВЧНӨӨР ҮХЭЖ БАЙГААТАЙ ХОЛБОГДУУЛАН ЭРГҮҮЛ, ХЯНАЛТЫН ПОСТ АЖИЛЛАЖ БАЙНА

Нэн ховор амьтан болох бөхөн мялзан өвчнөөр үхэж хорогдож байгаатай холбогдуулан сумд эргүүл хяналтын 2 пост, устгалын 2 цэг ажиллууллаа. Эдгээр цэгүүдэд сум орон нутгийн ажилгүй иргэдийг хөлсөөр ажиллуулж байна. Сондуулт Хамтын хүч багийн нутагт устгал хийх 2 цэг ажиллаж 19 зээр, 408 бөхөнг устгаж материалыг бүрдүүлэн холбогдох газарт нь хүргүүллээ.



Мэдээ бэлтгэсэн: ДАШБХ мэргэжилтэн Д.Ончимэг